



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Авто зам засвар, арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн Багануур дүүрэг дэх салбарын
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2026/003/НА-СТА-ТӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Нандинжаргал Утас: 7000-7734 Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn</p> <p>Санхүүгийн аудитын албаны ахлах менежер: Х.Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn</p> <p>Санхүүгийн аудитын албаны аудитын менежер: Я.Алтанцэцэг Утас: 315558 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Бэст фортуна аудит ХХК-ийн захирал: Ж.Оюунцэцэг Утас: 324338, 89116465 Цахим хаяг: fortune2009audit@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026-05-18 № 732
танай _____-ны № _____-Т

АВТО ЗАМЫН ЗАСВАР АРЧЛАЛТЫН
НЭГТГЭЛ ТӨХК-ИЙН БАГАНУУР
ДҮҮРЭГ ДЭХ САЛБАРЫН МЕНЕЖЕР
М.МЯГМАРЖАРГАЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Авто зам засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн Багануур дүүрэг дэх салбарын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар бүх явцыг санхүүгийн тайланд толилуулж, толилуулаагүй асуудал гараагүй болно.

Авто зам засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2025 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн А/89 дугаар тушаалаар тус салбарын 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд нийт орлогыг 3,478.0 сая төгрөг, нийт зардлыг 3,461.4 сая төгрөг, 16.6 сая төгрөгийн ашигтай ажиллахаар баталсан байна. Гүйцэтгэлээр 3,185.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 3,995.7 сая төгрөгийг зарцуулж, 810.5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Нийт орлогын гүйцэтгэл 91.6 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь бусад орлогын төлөвлөгөөг биелүүлэх боломжгүй (2025 онд салбар болж зохион байгуулалтын өөрчлөлт хийгдсэнээс бие даан тендерт орох эрх хязгаарлагдснаас шалтгаалсан)-ээс голлон шалтгаалсан байна.

1426050577

C:\Users\naranga\Desktop\Бичиг хэргийн 2026\2026\word\yywan bichig\Dugnet_2026.docx

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Засгийн газрын 2023 оны 220 дугаар тогтоолын дагуу өөрчлөн зохион байгуулагдсан Авто замын засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн дүрэмд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 108 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан, Авто зам засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн 2025 оны 25/06 дугаартай тогтоолоор Авто зам засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн Багануур дүүрэг дэх салбар болон зохион байгуулагдсан байна. Салбар болон зохион байгуулагдсанаар бие даан сонгон шалгаруулалтаар ажил олж хийх эрх хязгаарлагдсанаас бусад орлогын төлөвлөгөө тасарч алдагдалтай ажиллахад голлон нөлөөлсөн байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Авто зам засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2025 оны А/89 дугаартай тушаалаар баталсан компанийн тайлант оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг 89.1 хувиар биелүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайланд удирдлага болон засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

© Users\aranguu\Desktop\Бичир хэргэ 2026\2026\word\ywaan bichig\Diugnelt 2026.docx

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	<i>/төгрөгөөр/</i>	
		2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	590,897,365.41	73,743,939.78
1.1.2	Дансны авлага	272,895,407.93	462,163,182.67
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	17,944,290.74	15,757,607.04
1.1.4	Бусад авлага	-	367,603,453.62
1.1.6	Бараа материал	128,276,629.03	87,922,309.99
1.1.7	Урьдчилж төлсөн зардал, тооцоо	16,136,363.64	16,136,363.64
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,026,150,056.75	1,023,326,856.74
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,233,616,090.97	1,106,135,892.26
1.2.2	Биет бус хөрөнгө	340,450,000.00	339,130,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,574,066,090.97	1,445,265,892.26
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,600,216,147.72	2,468,592,749.00
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	3,141,970.00	16,372,142.24
2.1.1.2	Цалингийн өглөг	51,155.93	180,550.33
2.1.1.3	Татварын өр	13,988,231.38	105,892,606.92
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	-
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	486,145.00	
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	-	574,099,195.10
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	17,667,502.31	696,544,494.59
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	17,667,502.31	696,544,494.59
2.3	Эздийн өмч	2,541,829,486.13	2,541,829,486.13
2.3.1	Өмч: - төрийн	2,541,829,486.13	2,541,829,486.13
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	337,194,408.29	337,194,408.29
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	400,323,125.03	400,323,125.03
2.3.9	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(1,022,092,877.35)	(696,798,374.04)
2.3.10	Тайлант үеийн ашиг (алдагдал)	325,294,503.31	(810,500,391.00)
2.3.11	Эздийн өмчийн дүн	2,582,548,645.41	1,772,048,254.41
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	2,600,216,147.72	2,468,592,749.00

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

<i>/төгрөгөөр/</i>			
№	ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	5,981,901,496.36	3,182,828,787.46
2	Борлуулалтын өртөг	5,208,947,207.73	3,475,755,477.90
3	Нийт ашиг (алдагдал)	772,954,288.63	-292,926,690.44
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүний орлого	5,042,486.21	2,649,040.91
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	385000	-
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	416,632,326.71	438,493,881.59
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	280000	81,463,955.79
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг алдагдал	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	361,469,448.13	-810,235,486.91
19	Орлогын татварын зардал	36,174,944.82	264,904.09
20	Татварын дараах ашиг (алдагдал)	325,294,503.31	-810,500,391.00
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	325,294,503.31	-810,500,391.00
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	325,294,503.31	-810,500,391.00

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023-12-31-ний үлдэгдэл	0.00	0.00	0,00	0.00	0.00
2	НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	0.00	0.00
3	Залруулсан үлдэгдэл	2,541,829,486.13	337,194,408.29	336,000,000.00	-1,017,231,427.35	2,197,792,467.07
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	325,294,503.31	325,294,503.31
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
6	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	64,323,125.03	-	64,323,125.03
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	4,861,450.00	4,861,450.00
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
1	2024-12-31-ний үлдэгдэл	2,541,829,486.13	337,194,408.29	400,323,125.03	-696,798,374.04	2,582,548,645.41
2	НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	8,000,000.00	(24,326,886.81)	-16,326,886.81
3	Залруулсан үлдэгдэл	2,541,829,486.13	337,194,408.29	408,323,125.03	-721,125,260.85	2,566,221,758.60
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-810,235,486.91	-810,235,486.91
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
6	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
9	2025-12-31-ний үлдэгдэл	2,541,829,486.13	337,194,408.29	408,323,125.03	-1,531,360,747.76	1,755,986,271.69

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

		/төгрөгөөр/	
№	ҮЗҮҮЛЭЛТ	2024-12-31	2025-12-31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	6,702,593,101.85	2,663,207,253.75
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	6,544,197,211.00	2,637,304,952.87
	Бусад мөнгөн орлого	158,395,890.85	25,902,300.88
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	6,433,182,651.17	3,163,283,575.29
	Ажиллагчдад төлсөн	790,913,416.04	976,932,704.54
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	237,377,753.20	306,885,789.08
	Бараа материал худалдан авахад төлсөн	1,947,169,071.02	401,124,135.00
	Ашиглалтын зардалд төлсөн	43,539,922.26	25,537,452.94
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	912,247,836.40	345,745,870.09
	Хүүний төлбөрт төлсөн	21,039,606.08	-
	Татварын байгууллагад төлсөн	342,544,360.85	103,255,199.84
	Даатгалын төлбөрт төлсөн	5,994,723.76	6,327,103.76
	Бусад мөнгөн зарлага	2,132,355,961.56	997,475,320.04
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	269,410,450.68	(500,076,321.54)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	5,042,486.21	2,649,040.91
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Хүлээн авсан хүүний орлого	5,042,486.21	2,649,040.91
	Зээл, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	77,557,500.00	19,240,000.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	74,257,500.00	19,240,000.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	3,300,000.00	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(72,515,013.79)	(16,590,959.09)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	300,000,000.00	-
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	300,000,000.00	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	304,375,305.00	486,145.00
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	300,000,000.00	-
	Төлсөн ногдол ашиг	4,375,305.00	486,145.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(4,375,305.00)	(486,145.00)
	Валютын ханшийн зөрүү	-	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	192,520,131.89	(517,153,425.63)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	398,377,233.52	590,897,365.41
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	590,897,365.41	73,743,939.78

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/ төгрөгөөр/

№	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Зөрүү хувиар
1	Ээлжит засварын ажил	1,100,500,000.00	1,739,249,272.62	638,749,272.62	158.0
2	Өмнөх оны он дамжсан орлого	1,501,800,000.00	1,332,879,514.84	-168,920,485.16	88.8
3	Бусад орлого	875,700,000.00	113,349,040.91	-762,350,959.09	12.9
4	Нийт орлого	3,478,000,000.00	3,185,477,828.37	-292,522,171.63	91.6
5	Цалин	737,095,634.85	899,327,232.56	162,231,597.71	122.0
6	Бай-аас төлөх НДШ	109,462,492.34	126,873,366.12	17,410,873.78	115.9
7	Байгууллагын тогтмол зардал	40,956,032.45	22,295,020.15	-18,661,012.30	54.4
8	Гэрэл цахилгаан	40,273,532.45	21,719,020.15	-18,554,512.30	53.9
9	Цэвэр, бохир ус	204,750.00	-	-204,750.00	-
10	Дулаан халаалт	477,750.00	576,000.00	98,250.00	120.6
12	Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зардал	387,075,950.00	228,334,104.19	-158,741,845.81	59.0
15	Шатахууны зардал	344,424,460.00	137,569,786.18	-206,854,673.82	39.9
16	Тос, тосолгоо	42,651,490.00	90,764,318.01	48,112,828.01	212.8
17	Материал, хангамжийн зардал	928,655,500.00	995,927,477.99	67,271,977.99	107.2
18	Хангамжийн материал зардал	1,894,400.00	49,538,260.97	47,643,860.97	2,615.0
19	Материалын зардал	881,018,100.00	879,178,153.87	-1,839,946.13	99.8
20	Сэлбэг хэрэгсэл	45,743,000.00	67,211,063.15	21,468,063.15	146.9
21	Томилолт, сургалтын зардал	15,121,300.00	5,784,000.00	-9,337,300.00	38.3
22	Томилолт	7,521,300.00	1,956,000.00	-5,565,300.00	26.0
23	Сургалтын зардал	7,600,000.00	3,828,000.00	-3,772,000.00	50.4
24	Нэг удаагийн буцалтгүй тусламж, тэтгэмж, шагнал урамшуулал	11,128,000.00	45,597,143.78	34,469,143.78	409.8
25	Тэтгэмж	11,128,000.00	45,597,143.78	34,469,143.78	409.8
26	Бусад бараа үйлчилгээний зардал	478,192,538.26	1,132,706,359.93	654,513,821.67	236.9
27	Механизмын зардал	4,118,400.00	3,600,849.06	-517,550.94	87.4
29	Лаборатийн шинжилгээ	400,000.00	588,909.09	188,909.09	147.2
31	Хөдөлмөрийн аюулгүй байдлын зардал	39,829,000.00	31,580,890.97	-8,248,109.03	79.3
32	Ажилсагсадад үйлчлэх зардал	64,374,970.00	55,592,990.91	-8,781,979.09	86.4
33	Ажиллагсдын эрүүл мэндийн үзлэгийн төлбөр	5,550,000.00	7,583,500.00	2,033,500.00	136.6
34	Тээврийн зардал	37,000,000.00	24,757,563.63	-12,242,436.37	66.9
35	Машин, механизмын түрээс	45,000,000.00	144,318,181.81	99,318,181.81	320.7
36	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	104,000,000.00	724,392,203.63	620,392,203.63	696.5
38	Ахмадын зардал	-	-	-	-
39	Бусад зардал	15,077,620.00	14,316,078.06	-761,541.94	94.9
40	Элэгдэл	162,842,548.26	125,975,192.77	-36,867,355.49	77.4

41	Татвар, даатгал, төлбөр хураамж	187,619,320.00	18,910,773.18	-168,708,546.82	10.1
42	АТӨЯХөдөлгүүрийн татвар, үзлэг оношлогоо, даатгал	-	-	-	-
43	Агаарын бохирдол, ТХ-ийн үзлэг оношлогоо	1,539,210.00	880,300.00	-658,910.00	57.2
44	Тээврийн хэрэгслийн татвар	5,387,240.00	3,252,900.00	-2,134,340.00	60.4
45	Зам ашигласны төлбөр	769,610.00	4,780,000.00	4,010,390.00	621.1
46	Газрын төлбөр	999,280.00	959,280.00	-40,000.00	96.0
47	Үл хөдлөх хөрөнгийн татвар	2,880,060.00	2,711,189.42	-168,870.58	94.1
48	НӨАТ	160,950,720.00	-	-160,950,720.00	-
49	Даатгалын зардал	11,600,000.00	6,327,103.76	-5,272,896.24	54.5
50	Төлбөр хураамж бусад татвар	3,493,200.00	-	-3,493,200.00	-
51	Үйлдвэрлэлийн зардал	2,895,306,767.90	3,475,755,477.90	580,448,710.00	120.0
52	Цалин	388,514,631.19	329,244,428.31	-59,270,202.88	84.7
53	Байгууллагаас төлөх НДШ	53,577,730.47	41,451,134.75	-12,126,595.72	77.4
54	Байгууллагын тогтмол зардал	34,909,090.91	25,299,999.99	-9,609,090.92	72.5
55	Байрны түрээсийн зардал	34,909,090.91	25,299,999.99	-9,609,090.92	72.5
56	Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зардал	14,875,970.00	7,207,264.12	-7,668,705.88	48.4
57	Бичиг хэрэг, оффисын зардал	5,000,000.00	1,870,090.89	-3,129,909.11	37.4
58	Холбоо харилцаа, шуудан	3,143,970.00	2,689,971.32	-453,998.68	85.6
59	Шатахууны зардал	6,732,000.00	2,647,201.91	-4,084,798.09	39.3
60	Материал, хангамжийн зардал	505,600.00	-	-505,600.00	-
61	Хангамжийн материал зардал	505,600.00	-	-505,600.00	-
62	Томилолт, сургалтын зардал	14,398,000.00	1,608,000.00	-12,790,000.00	11.2
63	Томилолт	12,698,000.00	428,000.00	-12,270,000.00	3.4
64	Сургалтын зардал	1,700,000.00	1,180,000.00	-520,000.00	69.4
65	Нэг удаагийн буцалтгүй тусламж, тэтгэмж, шагнал урамшуулал	22,212,000.00	1,692,700.00	-20,519,300.00	7.6
66	Тэтгэмж	22,212,000.00	1,692,700.00	-20,519,300.00	7.6
67	Бусад бараа үйлчилгээний зардал	37,077,412.42	31,990,354.42	-5,087,058.00	86.3
68	Программ хангамж лиценз	1,710,000.00	1,140,000.00	-570,000.00	66.7
69	Аудитын зардал	6,000,000.00	6,000,000.00	-	100.0
70	Хөдөлмөрийн аюулгүй байдлын зардал	883,730.00	-	-883,730.00	-
71	Банкны үйлчилгээний зардал	480,000.00	156,300.17	-323,699.83	32.6
72	Ахмадын зардал	3,000,000.00	3,500,000.00	500,000.00	116.7
73	Бусад зардал	2,400,000.00	878,139.21	-1,521,860.79	36.6
74	Элэгдэл	22,603,682.42	20,315,915.04	-2,287,767.38	89.9
75	Удирдлагын зардлын дүн	566,070,434.99	438,493,881.59	-127,576,553.40	77.5
76	Үйл ажиллагааны бус зардал	-	81,463,955.79	81,463,955.79	-
77	Нийт зардал	3,461,377,202.89	3,995,713,315.28	534,336,112.39	115.4

78	Татварын өмнөх ашиг (+), алдагдал (-)	16,622,797.11	-810,235,486.91	-826,858,284.02	(4,874)
79	Орлогын татварын зардал	-	264,904.09	264,904.09	-
80	Цэвэр ашиг (+), алдагдал (-)	16,622,797.11	-810,500,391.00	-827,123,188.11	(23.4)

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 58,000.2 мянган төгрөгийн зөрчил¹ илэрч, 55,546.2 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 2,454.0 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгөв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний шинэчлэн тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан	Буруу тусган илэрхийлсэн				Үүнээс				Зөвлөмж
	Тоо	Дүн		Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		
								Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо
2024 онд гүйцэтгэсэн ажлын орлогыг тухайн ондоо орлого, авлагаар аккурэл сууриар бүртгээгүй, 2025 онд бүртгэж, тайлагнасан	1	408,415.4			1	408,415.4	1	408,415.4				
Тайлант хугацаанд ажиллагааг удаа урьдчилгаа цалин олгохдоо үндсэн цалингийн 60 хувийг хэтрүүлэн олгож, авлагын дансанд бүртгэж, 1-3 сарын хугацаанд суутгасан	1	19,700.0			1	19,700.0	1	19,700.0				
	2	428,115.4	0	0	1	19,700.0	3	459,525.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн хөрөнгийн данснаас ажиллагсадад олгож байгаа зарим томилолтын зардлыг дараа тайлангийн дансаар дамжуулаагүй, шууд зардалд бүртгэсэн	1	2,384.0					1	2,384.0				
Автомашинь торгуулийн шалтгааныг харгалзахгүйгээр, зохих шийдвэргүйгээр байгууллага төлж зардалд бүртгэсэн	1	70.0					1	70.0				
Татварын шалгалтаар 2021-2025 оны 4 дүгээр сар хүртэлх үеийн татварын нөхөн ногдуулалт 19,528,104 төгрөг 98 мөнгө, торгууль, алданги 55,546,213 төгрөг 36 мөнгөний акт тогтоогдсон	1	55,546.2			1	55,546.2						
Санхүүгийн тайланг төрийн аудитын байгууллагад хуульд заасан хугацаанд ирүүлээгүй	1	0.0					1	0.0				
Дүн	4	58,000.2	0	0	1	55,546.2	3	2,454.0				